


**ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДОНЧИР ОВОГТОЙ ЭРДЭНЭЖАРГАЛ**

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ, ДЭД БҮТЭЦ
- ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ БА АЖЛЫН БАЙР

D. Доржсүрэн




БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ


1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ –ын хаягдын аж ахуйн цагаан тоосыг дарах хамтарсан ажлын хэсэг байгуулж, цагаан тоосыг дарах
2. Унаган төрхтэй, ногоон Эрдэнэт хотыг хэвээр хадгалж үлдэх
 - a. Нийт шороотой талбайг зүлэгжүүлэх
 - b. Өрх бүрийг мод тариулж, амралт чөлөөт цагаа өнгөрөөх ногоон бүстэй болох
 - c. Агаар, хөрсний бохирдлыг бууруулах, урт хугацаанд байхгүй болгох
 - d. Эрдэнэт хотын Ерөнхий төлөвлөгөөг дахин боловсруулах, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх замаар орон сууцжуулах
3. Аялал жуучлалыг хөгжүүлэх зорилгоор мянганы зам дагуух дэд бүтцийг сайжруулах
 - a. “Эртний дурсгалаас Эрин цагийн бүтээн байгуулалт” сэдвийн хүрээнд “Айргийн гозгорын олдвор”-оос “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хүртэлх аялал жуулчлалын маршрутыг шинээр бий болгох
 - b. “Мянганы зам” дагуу орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний цогц төвийг байгуулах замаар орон нутгийн бизнес эрхлэгчид, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих

ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ БА АЖЛЫН БАЙР

1. БОЭТ-ийг тоног төхөөрөмжийг орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр сайжруулах, үйлчилгээний менежмент, ажилчнуудын мэргэжил ур чадварыг дээшлүүлж, өрсөлдөх чадварыг Олон Улсын жишигт хүргэх
2. Яаралтай түргэн тусламжийн дэд төвүүдийг гэр хорооллын хэсэгт бүсчилэн байгуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх
3. Ахлах болон их дээд сургуулийн зарим хичээл, номын санг цахим хэлбэрт шилжүүлэх
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлж, сурх орчин нөхцөлийг сайжруулах (мэдээллийн технологид суурисан дэвшилтэт орчин үеийн сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх)



5. Малын гаралтай түүхий эд боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрийг бодлогоор дэмжиж, 2-3 боловсруулах үйлдвэр байгуулах
 6. ХЭДС, ЖДҮ зээлийг өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд нээлттэй, ил тод зарчмаар олгуулах, эргэн төлөлтийг сайжруулах замаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажлын байр нэмэгдүүлэх, үүнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон орон нутгийн томоохон аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулах
 7. “Инновацийг дэмжих төвийг байгуулж, үндэсний болон олон улсын томоохон компани аж ахуйн нэгжүүдийн дэмжлэгтэйгээр “Старт апп” компаниудыг олноор байгуулах, үндэсний интрепрёнерүүдийг бэлтгэх
 8. Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг орон нутагт нэвтрүүлж, компани, аж ахуйн нэгж, нөхөрлөл зэргийг байгуулах, орон нутгийн тендер худалдан авалтийг бүрэн цахимжуулах замаар төрийн үйлчилгээний хүнд суртал, авлига хээл хахуулийг бүрэн таслан зогсооно.



[Signature]